



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/559

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дахь заалт, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газрын доройтол, элсний нүүлтийг сааруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр Хөхморьт сумд хийгдсэн 20 га талбайд элсний механик хамгаалалт хийх ажлын гүйцэтгэлийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүн:

- (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ой, хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн албаны дарга)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, ургамал гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- (Сумын Засаг дарга)
- (Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга)
- (Сумын байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
- (Сумын газрын даамал)

2.

Нарийн бичгийн дарга:-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Элсний механик хамгаалалтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан зураг төсөл, ажлын даалгавартай нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г. ЧИНБАТ